



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 03

Арвайхээр сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 1 дүгээр багт БУ-15/2021-БШУЯ/202102037+1+1 гэрээний дугаартай 4 дүгээр сургуулийн номын сан, урлаг заалны өргөтгөлийн барилга байгууламжийн угсралтын ажил дууссан тул “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу дунд төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0005

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны  
...дүгээр сарын ...-ны өдрийн  
...дугаар захирамжийн  
хавсралт



ДУНД ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ  
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН  
БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
- Гишүүд:
- Г.Түвшинтөр (аймгийн ерөнхий Архитектор)
  - Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
  - Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
  - С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)
  - Б.Өсөхбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)
  - С.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
  - Б.Баасанжав (Зураг төслийн “ММ архитектур” ХХК-ийн захирал)
  - Б.Даваадагва (“Онги ус суваг” ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)
  - М.Нинжбадгар (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Ахлах мэргэжилтэн)
  - Г.Энхболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн)
  - Д.Мөнх-Эрдэнэ (ЭБЦТС ТӨХК”-ийн ӨВ дахь салбарын ахлах диспичер)
  - Ц.Оюунтунгалаг (Өвөрхангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн)
  - Б.Баасансүрэн (“МХС” ТӨХК-ийн ӨВ аймаг дахь салбарын Кабель шугамын инженер)
  - Д.Мөнхболд (“МЦХ” ТӨХК-ийн ӨВ аймаг дахь салбарын инженер)
- Захиалагч: Г.Лхагва (ЕБ-ын 4 дүгээр сургуулийн захирал )
- Д.Загарсүрэн (ЕБ-ын 4 дүгээр сургуулийн сургалтын менежер)
- Гүйцэтгэгч: Д.Чойжилсүрэн (Гурван тахилгат оргил ХХК-ийн захирал)
- Н.Батбаатар (Гурван тахилгат оргил ХХК-ийн цахилгааны инженер)

Нарийн бичгийн дарга: С.Мөнхзаяа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Ч.Гомбосүрэн (Гурван тахилгат оргил ХХК-ийн ерөнхий инженер)



-оОо-